ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ЗӨВЛӨМЖИЙН ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Сайнцагаан 2023 оны 06 сарын 09-ний өдөр

| № | ХШҮХэлтэсээс өгсөн нийтлэг зөвлөмж | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хариуцах албан тушаалтан | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг аймгийн сайтад 5 сарын 1-ний дотор багтаан бүрэн байршуулах | 1.Аймгийн сайтад 05 сарын 1-ний дотор мэдээ мэдээлэл шалгуурын дагуу байршуулах | Шалгуур үзүүлэлт хангассан мэдээний тоо | 43 | 43 | Хагас жилийн байдлаар Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу 30 мэдээлэл шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн сайтад байршууллаа. 13 мэдээлэл нв бүрэн гараагүй байна. | 70 |
| 2 | Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдалд улирал бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангах | 2.Шилэн дансанд шаардлагатай мэдээллийг тогтмол оруулах | Шилэн дансны хэрэгжилтийн хувь | 84.3 | 90.0 | Эхний хагас жилийн байдлаар шилэн дансанд шаардлагатай 78 төрлийн мэдээ тайлан байршуулж 100 хувьтай хэрэгжүүллээ. | 100 |
| 3 | Тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх мэдээллийг Сангийн яамнаас батласан загвар маягт Хавсралт 1-ийн дагуу гаргаж, сумын ИТХурлаар батлуулан хэрэгжилт үр дүнг тооцож байх | 3.Хэрэгжсэн хөтөлбөрийн үр дүнг тооцох | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | - | 05 дугаар сарын байдлаар 3 төсөл хөтөлбөр хэрэгжиж 276,300.6 мянган төгрөгийн 10 нэр төрлийн арга хэмжээг санхүүжүүлж 42%-ийн хэрэгжилттэй байна. | 30 |
| 4 | Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан аймгийн ИТХТ-ийн 2020 оны 06 тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилт үр дүнг Орон нутгийн | 4.Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэх | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Сумын ӨХБЗөвлөл нь энэ оны ажлын төлөвлөгөөгөө сумын Засаг даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу 1 төсвийн байгууллагад хяналтын тооллого явуулж үр дүн зөвлөмжийг хүргүүллээ. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өмчийн газарт 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах | | | | | | |
| 5 | Улс болон орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь сар бүр жигд биелүүлэх | 5.Тухай бүр татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх | Орлогын биелэлтийн хувь | | | 05 дугаар сарын байдлаар 24 нэр төрлийн 319,899.7 мянган төгрөгийн ОНЕОрлого орж 75%-ийн биелэлттэй байна. | 70 |
| 6 | Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалт, цахим албан хэрэг хөтлөлтийн тайланд улирал бүр дүгнэлт хийж, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Төрийн захиргаа удирдлагын хэлтэст цахимаар хүргүүлэх | 6.Цахим албан хэрэг хөтлөлтийн тайланг улирал бүр холбогдох хэлтэст хугацаанд нь хүргүүлэх | Хэрэгжилтийн хувь | | | Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалт, цахим албан хэрэг хөтлөлтийн тайланг Төрийн захиргаа удирдлагын хэлтэст цахимаар хугацаанд нь хүргүүллээ. | 100 |
| 7 | Цахим хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж аймаг орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, пэйж хуудасны тандалтын тоог нэмэгдүүлэх талаар тогтмол анхаарч үр дүнг сар бүр тооцон ажиллах. | 7.Аймаг орон нутгийн мэдээллийг фэйсбүүк хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх | Фэйсбүүкээр дамжуулсан мэдээллийн тоо | 250 | 260 | Албан ёсны фэйсбүүк хуудсаар 240 гаруй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэлээ. | 70 |
| | | 8.Пэйж хуудасны дагагчдын тоог нэмэгдүүлэх | Дагагчийн тоо | 12.2 мянга | 13.0 мянга | Энэ оны хагас жилийн байдлаар сумын пэйж худас нь 12.5 дагагчтай боллоо. Энэ өмнөх оноос 300 дагагчаар ахисан үзүүлэлттэй байна. | 70 |
| 8 | Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэл, үүрэг даалгаврын цахим системд шилжиж, нийт албан хаагчдын цахим ур чадвар, тоон боловсролыг дээшлүүлэх. | 9.ERP системийн ашиглалт, цаг бүртгэл, үүрэг даалгаврын цахим системд шилжиж, тоон боловсролыг дээшлүүлэх арга | Арга хэмжээнд хамрагдсан албан хаагчдын хувь | 90 | 95 | Тус сумын ЗДТГазрын 32, харъяа төсөвт байгууллагын албан хаагч өдөр тутмын ажилд ERP нэгдсэн систем ашиглаж албан бичгийн хяналт олон, үүрэг даалгаврыг цахимаар ажиглаж хэвшээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээ зохион байгуулах | | | | | |
| 9 | Гадаад, дотоод сүлжээний зохион байгуулалт, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх замаар байгууллагын ERP болон төрийн сангийн системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангаж албан хаагчдын ажиллах нөхцөл боломжоор хангах | 10.Интернэтийн хурдыг нэмэгдүүлэх | Интернетийн хурдыг сайжруулах | | | Төрийн сангийн цахим систем, дотоод удирдлагын ERP систем цахим систем зэргийн хэвийн үйл ажиллагааг хангаж ЗДТГазрын интернэтийн хурд dedicated 10 mbps болж хэвийн ажиллаж байна. | 100 |
| 10 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах сумын орон тооны бус дэд салбар зөвлөл болон Залуучуудын хөгжлийн зөвлөлийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, төлөвлөгөө гарган батлуулж, тус зөвлөлүүдийн төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны дотор Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэх | 11.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах сумын орон тооны бус дэд салбар зөвлөл болон Залуучуудын хөгжлийн зөвлөлийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, төлөвлөгөө гарган батлуулах | Төлөвлөгөө батлуулсан эсэх тийм/үгүй | тийм | тийм | Сумын Засаг даргын 2021 оны А/100 дугаар захирамжаар сумын ЗХЗөвлөл, Сумын ХБИргэний эрх, оролцоог хангах орон тооны бус зөвлөл 2021 оны А/167 дугаар захирамжаар тус тус байгуулагдан 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. | 100 |
| | | 12.Зөвлөлүүдийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Хэрэгжилтийн хувь | 80 | 85 | Сумын ЗХЗөвлөл бусад зөвлөлүүдтэй хамтран Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Дугуйн уралдаан, 3*3 өсвөр насны сагсан бөмбөгийн тэмцээн, | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Эрчүүдээ хайрлая" тэмцээн, Бөхийн барилдаан, Эх орны төлөө цэрэгжилтийн спорт, нормативын аварга шалгаруулах цогцолбор тэмцээн, Эрдмийн баяр, Төгсөх ангийн сурагчдын уулзалт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт 1051 залуучуудыг оролцууллаа.<br>Аймгийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлтэй хамтран 2023-2024 оны хичээлийн жилд 5-6 настай цэцэрлэг суруульд хамрагдах 11 хүүхдийг багийн Засаг дарга, эцэг эх, сургууль, цэцэрлэгийн удирдлагуудтай хамтарсан өргөтгөсөн хурлыг зохион байгууллаа. ОУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр аймгийн Засаг дарга гарын бэлгэнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхүүдийг хамруулллаа. ГИЦС, 3-р цэцэрлэгт Тэгш хамруулах боловсролыг дэмжих төслийн хүрээнд ХБХ-ийн хөгжлийн танхимыг байгуулан, тоног төхөөрөмжөөр хангалаа.<br>Сумын ЗХЗөвлөл, ХБИргэний эрх, оролцоог хангах орон тооны бус зөвлөлийн төлөвлөгөөг тус бүр 70-тай хэрэгжүүллээ. | |
| 11 | 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | 13. 0-17 насны хүүхдийн судалгаа гаргах | Судалгаа гаргасан эсэх тийм/үгүй | тийм | тийм | Сумын 0-17 настай хүүхдийн тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 5949 хүүхэд байна. | 100 |
| | | 14. Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх | Үзлэгт хамрагдсан хүүхдийн хувь | - | 90 | 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор сумын Засаг даргын удирдамжаар үзлэгийг зохион | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллаа. Хамрагдалт 4032 буюу 67.7% | |
| 12 | Сумын нийт өрхийн 50-иас доошгүй хувийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг Соёл урлагийн газарт 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах | 15. “Угийн бичиг”-ийн аян зохион байгуулах | Аяны хэрэгжилтийн хувь | 55 | 57 | “Удам судраа мэдэж Угийн бичгээ хөтөлцгөөе” аяны хүрээнд төсөвт байгууллагын 620 гаруй албан хаагч, цахимаар 2300 гаруй иргэнд мэдээллийг хүргэлээ.“Удам судраа мэдэж Угийн бичгээ хөтөлцгөөе” аяныг 3 сарын хугацаатай зохион байгуулж, 2023 оны 1 сард шалгаруулан 1-р байр 8-р цэцэрлэг, 2-р байранд Хүмүүнлэг сургууль, 3-р байранд 2-р цэцэрлэг шалгарлаа. | 100 |
| 13 | Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, явцын тайланг Нийгмийн бодлогын хэлтэст 6, 11 сарын 10-ны дотор ирүүлэх хагэмт ахрэгиагам | 16. ТАХаагчдыг монгол бичгийн түвшинг ахиулах арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 2 | 2022-2023 оны хичээлийн жилд анхан, дунд, цахим монгол бичгийн сургалтад 223 албан хаагч сумын хэмжээнд модуль сургалтад хамрагдаж байна. Байгууллагууд сургалт зохион байгуулсан 5 албан хаагчдад 1.770.000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Аймгийн хэлний бодлогын зөвлөлтэй хамтран Үндэсний бичиг үсэг баярын хүрээнд ТАХ-ын дунд Цахим бичвэрийн уралдаан, Их сорилго уралдаануудыг хамтран зохион байгууллаа. Мөн аймгийн Тэргүүний уншигч шалгаруулах сурагчдын уралдааныг аймгийн төв Номын сантай хамтран зохион байгуулж, 765000 төгрөг, БШУГ-тай хамтран ЕБС-ийн 7-р ангийн 395 сурагчдын дунд 3 үе шаттай зохион байгууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 17. Төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох хэлтэст хугацаанд нь хүргүүлэх | Хэрэгжилтийн хувь | - | 80 | Сумын хэлний бодлогын зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг 90% хэрэгжүүлэн , БШУГ-т тайланг хүргүүллээ. | 100 |
| 14 | Эрх зүйн хөтчүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулан судлан сурталчлах хууль эрх зүйн актын жагсаалтын дагуу улирал бүр 4-өөс доошгүй эрх зүйн сургалтыг иргэд, олон нийтэд зохион байгуулж тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор ХЭЗХэлтэст ирүүлэх | 18. Иргэдэд 2023 онд судлан сурталчлах хуулиар улирал бүр 4-өөс доошгүй эрх зүйн сургалт хийх | Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо | 4100 | 4300 | Иргэдэд 2023 онд судлан сурталчлах хуулиар улирал бүр 4-өөс доошгүй эрх зүйн сургалт хийх<br>- Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ? сэдэвт сургалтыг 9 багийн 45 иргэнд 3 удаа зохион байгуулж, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Хөдөлмөрийн болон туслах малчинтай байгуулах гэрээ”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” зэрэг хуулиар сургалт зохион байгуулж тус бүр 35, нийт 105 албан хаагч хамрагдаж, 14 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч "Хайрлая хүндэлье", "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлье", “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлье” зэрэг постерийг багуудын цахим хуудсаар дамжуулан 4948 иргэний хандалттай байна. | 100 |
| | | 19. Зохион байгуулсан ажлын тайланг хугацаанд нь хүргүүлэх | Хэрэгжилтийн хувь | 91 | 93 | 05 сарын 24-ны өдөр Сумдын “Эрх зүйн хөтөч” нарыг чадавхжуулах сургалтад сумын ЗДТГ-ын НБМэргэжилтэн, ХЭЗМэргэжилтэн, ЕБС-ын нийгмийн ажилтан, Насан туршийн боловсролын багш, ЭМТөвийн сургалт хариуцсан | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтан зэрэг 40 албан хаагчийг хамрууллаа. Хагас жилийн байдлаар 70%-тай хэрэгжүүлээд байна. | |
| 15 | Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож тайланг ТЗУХэлтэст 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах | 20. “Хүний нөөцийг хөгжүүлэх” ажлын төлөвлөгөө боловсруулах | Төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй байгууллагын тоо | 14 | 14 | Сайнцагаан сумын “Хүний нөөцийг хөгжүүлэх” ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2 зорилт 14 арга хэмжээ тусган хэрэгжүүлж байна. | 100 |
| | | 21. Төлөвлөгөний биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх | Биелэлтийн хувь | 91.3 | 93.0 | Сумын “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд хүргүүллээ. | 100 |
| 16 | Төрийн албаны тухай хуулийн 55.3-ын дагуу байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, үр дүнг хагас бүтэн жилээр тооцож байх. | 22. Байгууллагууд албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хэрэгжилтийн хувь | 82.0 | 85.0 | Байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж хагас жилийн байдлаар 54,8%-тай хэрэгжээд байна. | 70 |
| | | | | | | | **Хэрэгжилт-84.5%** |

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА С.БАТ-ОРГИЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ЛХАГВАСҮРЭН